

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС**

ТАНИЛЦУУЛГА

**Хяналт шинжилгээ хийж, өгсөн зөвлөмжийн
хэрэгжилтийн тухай**

2019.10.04

Улаанбаатар хот

Газрын 2019 оны гүйцэтгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт шинжилгээ хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан тайлан мэдээнд хийсэн хяналт шинжилгээ 4 удаа, удирдамжийн дагуу 5 удаагийн, нийт 9 удаагийн хяналт шинжилгээний ажлыг хийлээ.

Удирдамжийн дагуу хийсэн хяналт шинжилгээ, түүний хэрэгжилт

Хүснэгт 1

1	Зөвлөмж	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
1	2	3	4	5
1. Үйлчилгээний албаны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ				
1.1	НЗЗ-ны байруудын цэвэрлэгээний сайжруулах, чанарыг	Үйлчилгээний ажилтнуудын ажлыг сайжруулах зорилгоор НЗЗ-ны байруудын үйлчилгээний ажилтан бүрт Хяналтын хуудас, Үнэлгээний хуудсыг боловсруулан гаргаж 2019.06.03-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.	95%	НЗЗ-ны 3-р байр, НҮНТ-ийн Мишээл, Драгон төвүүдэд хяналтын хуудсыг байр хариуцсан менежер бөглөсөн
1.2	НЗЗ-ны 5 дугаар байрны А корпусын хорхой шавжыг устгах,	НЗЗ-ны 5-ын А байранд 3000 м кв талбайд "Улаанбаатар ариутгал" ХХК-наас 3 төрлийн бодисыг цацаж, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн.	100%	
1.3	НЗЗ-ны 5 дугаар байрны А корпус, НҮНТ-ийн Дүнжингарав, Драгон салбаруудын ажилтнуудын цэвэрлэгээний багаж, хэрэгсэл, материалын эмх цэгцийг сайжруулах,	Цэвэрлэгээний багаж, хэрэгсэл, материалын эмх цэгцийг сайжруулахын тулд байгаа материалаар дотоод нөөц бололцоогоо ашиглан 5-ын А, Б, В байруудад ажлын багаж хэрэгсэл тавих тавиуриудыг хийлгэж будаж өнгө төрхийг нь сайжруулсан.	80%	Зарим байруудын ажилтнуудын багаж хэрэгсэлийн эмх цэгц шаардлага хангахгүй байдалтай байна.
1.4	Хангалттай үнэлгээ авсан бусад үзүүлэлтийн үнэлгээг бууруулахгүй ажиллах,	Хэрэгжилтийг дараагийн ХШҮ-ээр тооцно	-	
1.5	Зоог, цайны газруудад анхан шатны тусламж үзүүлэх эмийн сантай болох,	ННҮГ-ын зоогийн газар, цайны газруудад иж бүрэн эмийн сан, даралт хэмжих багаж зэргийг авч, байршуулсан.	100%	
1.6	Улаанбаатар чуулгын цайны газарт Бэлтгэсэн хоол, хүнснээс дээж авч хэвших, бүртгэл хөтлөх,	Боловсруулсан хоол, хүнснээс өдөр тутам дээж авч, түүнийгээ бүртгэн 72 цаг хадгалсны дараа бүрэн устгал хийж тэмдэглэл хөтөлж байна.	100%	

1	2	3	4	5
1.7	Зоог, цайны газарт хөтлөгдөх шаардлагатай бүртгэлүүдийг бүрэн, тогтмол хөтөлж хэвших,	ННҮГ-ын зоогийн газар, цайны газруудад хөтлөгдөх шаардлагатай 10 төрлийн бүртгэл, маягтуудыг хөтөлж хэвшиж байна.	90%	Зарим бүртгэл тогтмол хөтлөгдөөгүй
1.8	НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын мэдээллийн самбарт холбогдох дүрэм, журам, стандарт, мэдээллийг тогтмол байрлуулах,	НЗДТГ-аас болон байгууллагын удирдлагуудаас гарсан холбогдох дүрэм, журам, стандарт, мэдээллийг НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын мэдээллийн самбарт байршуулан тавьсан.	100%	
1.9	ХАБЭА-н дэвтэр хөтлөлтийг тогтмолжуулах	ХАБЭА-н дэвтэр хөтлөлтийг тогтмол хөтөлж хэвшсэн байна.	100%	
2. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн ХШҮ				
2.1	Ажилтан, албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтрийг тухай бүр нь баталгаажуулж хэвших,	Давхардсан тоогоор 280 гаруй хүний нийгмийн даатгал, эрүүл мэндийн дэвтрийг ЧД-ийн НДХ-ийн хариуцсан байцаагчийн шаардлагын дагуу улиралд 1 удаа баталгаажуулан ажиллаж байна.	100%	
2.2	Эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодсон тухай нэмэлт дэвтэр хөтөлж хэвших,	Эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж тооцоо бодож ажиллаж байна.	100%	
2.3	Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан, албан хаагчдын эд хөрөнгийн тооцоог хийхдээ акт үйлдэж хэвших,	Ажлаас гарсан албан хаагчидтай тойрох хуудсыг үндэслэн эд хөрөнгийн болон цалин хөлс, амралтын тооцоог хийж хэвшсэн.	100%	
2.4	Бараа, материалын агуулахад байгаа бараа, материал, эд хөрөнгийн эмх цэгцийг сайжруулах, бүрэн хаягжуулах, эд хөрөнгийн хадгалалтыг сайжруулах,	Агуулахын бараа материал, эд хөрөнгийн эмх цэгцийг сайжруулж бүрэн хаягжуулж, хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.	100%	
2.5	Бараа, материалын агуулахын дэвтрийн хөтлөлт, баталгаажуулалтыг хийх,	Агуулахын дэвтрийг иж бүрэн хөтөлж хэвшсэн.	100%	
2.6	Бэлтгэн нийлүүлэгч болон бусад байгууллагатай хийсэн гэрээ хэлцэл, нийлүүлж байгаа бараа материал, үйлчилгээний баримтын иж бүрдлийг хангах,	Харилцахын баримтанд холбогдох материалуудыг хавсаргаж хэвшсэн.	100%	
2.7	Хүнсний материалын тооцоог сар бүр бодож хэвших,	Хүнсний материалын тооцоог сар бүр бодож, технологийн картын дагуу орц нормоор нь бодож бүртгэлд тусгаж байгаа.	100%	
2.8	Хүнсний материалын агуулахын эмх цэгцийг сайжруулж, бүрэн хаягжуулах,	Хүнсний материалын агуулахын эмх цэгцийг сайжруулсан.	100%	
2.9	Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг, эрүүл ахуйн дүгнэлтийг тухай бүр нь авч зоогийн газарт хүлээлгэн өгөх,	Хүнсний материал хүлээн авахдаа шинжилгээний бичиг, эрүүл ахуйн дүгнэлтийн бичгийг авч зоогийн газруудад өгч байгаа.	100%	

1	2	3	4	5
2.10	2018 оны санхүүгийн тайлан, аудитын зөвлөмжийг цахим хуудаст байршуулах,	2018 оны санхүүгийн тайлан, аудитын зөвлөмжийг цахим хуудсанд байршуулсан.	50%	
2.11	Ажилтан, албан хаагчдыг эд хөрөнгө шилжүүлэх, зөөвөрлөхдөө эд хөрөнгө хүлээлцэх актыг тогтмол хөтөлж хэвшүүлэх,	Эд хөрөнгийг гаргах, шилжүүлэх, зөөвөрлөхөд "НХМ БМ4" маягтыг хөтөлж, хүлээлцэж хэвшсэн.	100%	
3. Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд хийсэн ХШҮ				
3.1	Сувилагч Т.Шашиймаагийн лицензийг яаралтай сунгуулах,	Сувилагчийн эмчлэх эрхийн лицензийн давтан шалгалтын хуваарь хүлээж байгаа болно.	50%	
3.2	Сувилагч бүртгэлийн дэвтэрт бүртгэлийг бүрэн тогтмол хөтөлж хэвших,	Сувилагч анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн өдөр тутмын бүртгэлийг хөтөлдөг болсон.	100%	
3.3	Өдөр тутмын бүртгэлийн дэвтэрт заавар өгсөн нарийн мэргэжлийн эмчийн нэр эсвэл эмнэлэг, тасгийг тогтмол бичиж хэвших,	Өдөр тутмын бүртгэлийн дэвтэрт эмчилгээний заавар өгсөн нарийн мэргэжлийн эмчийн нэр, эмнэлэгийн нэрийг бичиж байна.	100%	
3.4	Үйлчлүүлэгчээс санал хүсэлтийг дэвтэрт тогтмол авч байх,	Үйл ажиллагааны чанарыг сайжруулах үүднээс үйлчлүүлэгчийн санал хүсэлтийн дэвтэрийг идэвхтэй ажиллуулж байна.	100%	
3.5	Эм эмнэлэгийн хэрэгсэлийн хадгалалтын хэм болон агаарын харьцангуй чийгшилтийг хэмжиж байх температур, чийгшил хэмжигчтэй болох,	Яаралтай хэрэглэгдэх эмийн шүүгээнд температур мөн чийгшил хэмжигч авч байршуулсан.	100%	
3.6	Нэг удаагийн цаасан алчуур хэрэглэж хэвших,	Эмч, сувилагчийн гар угаах хэсэгт 1 удаагийн цаасан алчуур хэрэглэж хэвшсэн.	100%	
4. Байр ашиглалтын албаны үйл ажиллагаанд хийсэн ХШҮ				
4.1	НЗЗ-ны 1-р байрны цайны газрын угаалтуураас ус гоождогийг шийдвэрлэх,	НЗЗ-ны 1-р байр буюу НЗДТГ-ын байрны зоогийн газрын угаалтуур хуучирч муудан ус гоождог байсныг шинээр сольж шинэчилсэн.	100%	
4.2	НЗЗ-ны 1-р байрны узелийн өрөөний цонхнууд хагарсныг битүүлэх,	НЗЗ-ны 1-р байрны узелийн өрөөний цонх шилгүй, панераар хаасан байсныг шиллэж битүүлсэн.	100%	
4.3	НЗЗ-ны 3-р байрны зоорийн давхрын цахилгааны утаснуудыг сантехникийн шугам хоолойноос тусгаарлаж, цэгцлэх,	НЗЗ-ны 3-р байрны зоорийн давхрын цахилгааны утсыг сантехникийн шугам хоолойноос тусгаарлаж янзалсан.	30%	Бэлтгэл ажлын хангасан
4.4	НЗЗ-ны 3-р байрны гадна хананд байрлах эд зүйлсийн өнгө үзэмжийг сайжруулах,	НЗЗ-ны 3-р байрны гадна фасадны өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор хананд байрлах тугны иш суурийг будсан, гадна шатны хагарсан чулуун шатыг зассан, шатны дээр байх саравчны өнгийг сэргээж будахаар бэлтгэл ажлаа хангасан болно.	100%	
4.5	Үүдний шатыг засварлах,	НЗЗ-ны 3-р байрны төв хаалганы хагарсан чулуун шатыг шинэчилж засварласан.	100%	
4.6	НЗЗ-ны 3-р байрны узелийн шугамын хаалтыг солих,	НЗЗ-ны 3-р байрны узелийн шугамын хаалтыг сольсон.	100%	

1	2	3	4	5
4.7	НЗЗ-ны 4-р байрны зарим хэсэгт дусаал гоожиж байгааг шийдвэрлэх,	НЗЗ-ны 4-р байрны шилэн фасад болон дээврийн зарим хэсгээс борооны ус гоожиж байсны хар цаасан дээврийг өөрсдийн хүн хүчний нөөц бололцоог ашиглаж засаж янзалсан	100%	
4.8	НЗЗ-ны 4-р байрны хяналтын 5 камер ажиллахгүй байгааг засварлах,	НЗЗ-ны 4-р байрны 5ш хяналтын камер эвдэрч ажиллахгүй байсныг засаж янзлан бүрэн ажиллагаатай болгосон.	100%	
4.9	НЗЗ-ны 5-р байрны узелийн хаалтуудын жийрэг солих,	НЗЗ-ны 5-р байрны узелийн ялтсан бойлерийн хаалтуудыг бүрэн сольж шинэчилсэн	100%	
4.10	НЗЗ-ны 5-р байрны узельд халаалтын шугамыг пластик хоолойгоор хийснээс тосоол байнга гоождог, өндөр өртөгтэй халаадаг тул тус пластик шугамыг солих,	НЗЗ-ны 5-р байрны узельд байх тайзны халаалтын пластик хоолойг төмөр хоолойгоор солих ажлыг Улаанбаатар чуулгаас санхүүжүүлж хийлгэхээр болсон ч түр саатсан бэлтгэл ажлаа хангасан байдалтай байна.	80%	
4.11	НЗЗ-ны 5-р байрны А корпусын зоорийн давхрын агааржуулалтын хоолой хогоор дүүрснийг цэвэрлэх,	НЗЗ-ны 5-р байрны зоорийн давхрын агааржуулалтын хоолой хогоор дүүрснийг цэвэрлэж агаар сэлгэлтийн урсгалыг чөлөөтэй болгосон.	100%	
4.12	НЗЗ-ны 5-р байрны В корпусын үүдний дээвэрт ус тогтож нуралт үүсэх эрсдэлтэй болсныг засварлах,	НЗЗ-ны 5-р байрны В корпусын үүдний дээвэрт ус тогтож нуралт үүсэх эрсдэлтэй байсан хар цаасан дээврийг төмөрлөж усны хаялгыг хоёр тийш нь гаргаж өгч зассан	100%	
4.13	НЗЗ-ны 1, 2 дугаар байруудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчлэх,	НЗЗ-ны 1, 2-р байруудад аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчилсэн.	100%	
4.14	НЗЗ-ны 1-р байр, 5-р байрны А корпуст цахилгааны шитны өрөөг бусад зориулалтаар ашиглахгүй байх,	НЗЗ-ны 1, 5-р байрны цахилгааны шитны өрөөг бусад зориулалтаар ашиглахгүй байхаар зохицуулалт хийж байгаа	50%	
4.15	НЗЗ-ны байруудын цахилгааны шитүүдэд галын аюулгүй байдлыг хангаж, галын хорыг нормын дагуу байрлуулах, гал унтраах багаж, хэрэгсэл, элс байрлуулах,	НЗЗ-ны байруудын цахилгааны шитны өрөөнд галын аюулгүй байдлыг хангаж, галын хор, гал унтраах багаж хэрэгслийг байрлуулсан	80%	
4.16	НЗЗ-ны байруудын дулааны шугамуудыг ялгарах өнгөөр гүйцээн будаж, тоног төхөөрөмж, хаалт арматурт бирк, бичилт хийх,	НЗЗ-ны байруудын дулааны шугамуудыг зэврэлтээс хамгаалах будгаар будаж, ялгарах өнгийн зориулалтын туузаар ороож, бичилт хийх ажлыг хэрэгжүүлж байна	80%	
4.17	НЗЗ-ны 1, 3-р байруудын цахилгааны монтажны схем зургийг нөхөн бүрдүүлэх,	НЗЗ-ны 1, 3, 4-р байруудын цахилгаан монтаж, сантехник, агааржуулалтын схем зургуудийг нөхөн бүрдүүлэхээр Архивын	80%	
4.18	НЗЗ-ны 1, 3, 4-р байруудын сантехникийн шугам, хоолойн схем зургийг нөхөн бүрдүүлэх,		80%	

1	2	3	4	5
4.19	НЗЗ-ны 1, 3, 4-р байруудын агааржуулалтын схем зургийг нөхөн бүрдүүлэх,	ерөнхий газарт хүсэлт гаргасан болно.	80%	
5. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хийсэн ХШҮ				
5.1	Архивын гэрчилгээг шинээр авах,	Байгууллагын архивд шинээр гэрчилгээ авах хүсэлтийг 2019 оны 07 сарын 24-ны өдрийн 401 дүгээр албан бичгээр хүсэлт гаргасан.	100%	
5.2	Архивын өрөөнд тохиолдож болох гэнэтийн онцгой байдлын үед баримтыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг гарган батлуулах,	Архивын өрөөнд тохиолдож болох гэнэтийн онцгой байдлын үед баримтыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулж гарган батлуулсан.	100%	
5.3	Архивын өрөөнд ил байгаа сантехникийн шугам, хоолойг далдлах,	Архивын өрөөнд ил байгаа сантехникийн шугам, хоолойг дэсби хавтангаар бүрэн гүйцэд далдалсан.	100%	
5.4	Чийг, дулааныг хэмжиж бүртгэл тогтмол хөтлөх,	Чийг, дулааныг хэмжиж бүртгэлийн дэвтэрийг тогтмол хөтлөн ажиллаж байна.	100%	
5.5	Цэвэрлэгээ хийсэн тухай бүртгэл хөтлөх,	Цэвэрлэгээ хийсэн тухай бүртгэлийн дэвтэрийг тогтмол хөтлөн ажиллаж байна.	100%	
5.6	Архивын данс бүртгэлийн дэвтэр хөтлөх,	Архивын данс бүртгэлийн дэвтэр хөтөлж хэвшсэн.	100%	
5.7	Ажилтан, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж дуусгах,	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлэлтийг 100% шинэчилж дуусгав.	100%	
ДУНДАЖ ГҮЙЦЭТГЭЛ			91.6%	

Байгууллагын нэгжүүдийн үйл ажиллагаанд 2019 онд хийсэн хяналт, шинжилгээний дүнд нийт 52 төрлийн ажил сайжруулах тухай зөвлөмж өгсөн ба хэрэгжээгүй зөвлөмж байхгүй бөгөөд зарим гадаад хүчин зүйлээс шалтгаалан биелээгүй тохиолдлууд байлаа. Нийт зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувь 91.6% байна.

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН



Т.ИТГЭЛ